



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2025 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн яамны Ёс зүйн дэд хорооны гишүүдийг нөхөн томилох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4, 2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажиллаж байсан тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Г.Түвшинбаяр, Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Бат-Ундрал нар үүрэгт ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан яамны албан хаагчдын санал асуулгын дүнг үндэслэн Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч Д.Баясгалан, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч Д.Батдулам нарыг Ёс зүйн дэд хорооны гишүүнээр нөхөн томилсугай.

2.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг хуульд заасан харьяаллын дагуу шалган шийдвэрлэж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулж, журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг ахлах шинжээч Д.Баясгалан, шинжээч Д.Батдулам нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Эрдэнэтуяа)-т даалгасугай.

ДАРГА

Н.ЭРДЭНЭБАЯР

142260512